



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/368

Есөнбулаг сум

Албаны нууцад хамаарах мэдээллийн
жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг, Тагнуулын ерөнхий газрын ТЕГ01/391 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Холбогдох хууль, журмын дагуу албаны нууцын зохион байгуулалтыг хариуцаж, ажлын нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг аймаг, сумын нууц хамгаалах ажилтнуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/209 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 24-ны өдрийн 0307 дүгээр
захирамжийн хавсралт

АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт
1	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, хүч хэрэгслийн тооцоо, судалгаа, арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл (сумын хэмжээнд)
2	Сумын дайчилгааны даалгавар, төлөвлөгөө
3	Цэргийн бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдсан хүмүүсийн нэгдсэн мэдээлэл (сумын хэмжээнд)
4	Цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо (сумын хэмжээнд)
5	Аймаг, сумын Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
6	Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч
7	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
8	Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж
9	Байгууллага, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл
10	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл
11	Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр